

## ХӨГЖЛИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛД

Б.Наранбаатар\*

\* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, доктор (Ph.D)

**Түлхүүр үг:** хөгжлийн сэтгүүл зүй, ОНМХ-ийн редакци, Засгийн газар, Үндэсний хөгжлийн бодлого, сэтгүүлчийн хараат бус байдал, суртал ухуулга, ОНМХ-ийн нийгмийн хариуцлага

**М**эдээллийн технологийн хөгжил, Интернет хэрэглээний өсөлтийн дүнд олон нийтийн мэдээлэл харилцааны бүтэц, агуулга, хэлбэрт зогсолтгүй өөрчлөлт гарч, сэтгүүл зүйн уламжлалт үзэл баримтлал, онолууд шинэ сорилтыг даван туулах, хувьсан өөрчлөгдөх, хөгжлийн шинэ гарцаа эрэлхийлэн баталгаажуулах үйл явц өдгөө ид өрнөж байна.

Зөвхөн Монголд гэлтгүй, олон улс оронд тогтмол хэвлэлийн захиалга, борлуулалт буурч, телевизийн “цэвэр сэтгүүл зүйн” нэвтрүүлэг, мэдээллийн орон зай шахагдан инфо-тайнмент шинж чанар давамгайлах болсон нь өнөөгийн ОНМХ-ийн зах зээлийн үнэн төрх билээ. Энэ нөхцөлд хэрэглэгчийн мэдээлэл хүлээн авч буй олон хэрэгслээс мэргэжлийн сэтгүүл зүй юугаар онцгойрч олон нийтийг татах вэ, хадгалж үлдэх вэ гэсэн асуулт онол, практикийн түвшинд маргаан дагуул-

саар нэлээд хугацааг үдлээ. Маркетинг, менежментийн түвшинд багагүй алхмууд хийгдэж, шинэ гарцууд эрэлхийлэн хэрэгжүүлж байгаа боловч, чанартай сэтгүүл зүйг тодорхойлогч өдөр тутмын сонин, телевизийн мэдээллийн хөтөлбөр, ярилцлага хэлэлцүүлгийн нэвтрүүлгүүд нь хэрэглэгчийн хандлагын үүднээс авч үзвэл олон нийтийн сүлжээ, мэдээллийн портал сайт, эсвэл телевизийн олон ангит кино, цэнгээнт нэвтрүүлгүүдэд “ялагдсаар” удлаа<sup>1</sup>.

Медиа зах зээлийн топ-менежерүүд, хувь заяандаа санаа тавьдаг сэтгүүлчид, салбарын судлаачид тэр бүү хэл бизнесийн шинийг санаачлагч нар ур ухаанаа уралдуулан сэтгүүл зүйн ойрын болон дунд хугацааны ирээдүйг тандаж, өөр өөрийн зураглалыг санал болгож буй юм. Тухайн улс орны эдийн засгийн чадамж, ОНМХ-ийн системийн онцлог, үндэсний зорилго, зорилтуудаас хамаарч медиа зах зээлийн прогнозууд өөр өөр гарч байгаа бөгөөд энэ нь даяар хандлагатай давхцах албагүй бололтой.

Улс төр, шинжлэх ухаан, утга зохиолоос “угшил”-тай гурван тулгуур

болох үзэл бодол, баримт нотолгоо, уран сайхан гэсэн тулгын гурван чулуутай байсан уламжлалт сэтгүүл зүй өдгөө улс төр, нийгэм, бизнесийн эрх ашгийг илэрхийлэх үүрэг хүлээсэн олон нийтийн харилцааны ээдрээтэй талбар болж хувирчээ. Өөрөөр хэлбэл, төр баригчдын мэдээллийн орчныг хянах эрмэлзэл, бизнесийнхний ашиг орлого, нэр хүндийн төлөөх маркетингийн харилцаа, иргэний нийгмийн мэдэх, эрх ашгаа хамгаалах хэрэгцээ аль алинд нь медиа зах зээл үйлчилж байна.

Сэтгүүл зүй, сэтгүүлчийн тухай уламжлалт ойлголтууд шинжлэх ухааны түвшинд ч, хэрэглээний түвшинд ч өөрчлөгдөн хувьсаж байгаа. Гэвч олон нийтийн эрх ашгийг хамгаалах эрхэм үүргээ сэтгүүлч “мартаагүй” байгаа нөхцөлд л сэтгүүл зүй цэвэр утгаа хадгалан орших юм<sup>2</sup>. Хэчнээн улиг болсон мэт сонсогдовч чухам энэ л сэтгүүл зүйн чиг баримжааг тодорхойлох “Алтан гадас” юм. Ер нь ОНМХ бүрийн эрхэм зорилгод “нийгмийн сайн сайхны төлөө”, “нийгэмд үйлчлэх” гэсэн үзэл санаа оршиж, сэтгүүлчийн үйл ажиллагаагаар илэрдэг (ядаж тийм хэвээр байгаа гэж итгэхийг хүснэ – зохиогч).

Судлаачийн хувиар энэхүү өгүүлээр дамжуулан Монголын сэтгүүл зүйд шинэ хандлага болж, мэргэжлийн сэтгүүл зүйн хөгжих гарц болох бодит

боллоцоо бүхий шинэ бөгөөд хуучин нэгэн чиг баримжааг санал болгож буй юм.

Аль ч цаг үед улс орны хөгжлийн тухай асуудал ОНМХ-ийн тэргүүн сэдэв чиглэл байсаар ирсэн. Энэ асуудалд хэрхэн хандаж байгаагаар нь сэтгүүл зүйн уламжлалт онолуудыг дахин сөхөн харж дүгнэлт хийж ч болно. Авторитари, либертари, нийгмийн

хариуцлагын гэж нэрлэгдсэн сэтгүүл зүйн үндсэн гурван онолд хөгжлийн тухай асуудлыг тусгайлан “зааж өгсөн” нь бий<sup>3</sup>.

Тухайлбал, авторитари онолын үүднээс хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь төрд үйлчилж, түүний нийгэм, улс төр, эдийн

засгийн бодлогыг дэмжин, сурталчилж ажилладаг бөгөөд ийм нөхцөлд улс орны хөгжлийн асуудал нь нийгмийн үнэт зүйлийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, нэг цонхны бодлого хэрэгждэг. Ийм нөхцөлд ОНМХ-үүд нь төрөөс тодорхойлон хэрэгжүүлж буй үндэсний хөгжлийн бодлогыг ямар ч шүүмж, хэлэлцүүлэг, альтернатив сонголтгүйгээр сурталчлан таниулж, түүнийхээ “шан”-г хүртэн оршин тогтнох бололцоотой. Энэ нь зөвхөн улс төрийн авторитари засаглалын тогтолцоонд бий болох албагүй ба өөрийн гэсэн давуу болон сул талтай.

Либертари болон нийгмийн хариуцлагын үзэл баримтлалууд ч

«

*Улс төр, шинжлэх ухаан, утга зохиолоос “угшил”-тай гурван тулгуур болох үзэл бодол, баримт нотолгоо, уран сайхан гэсэн тулгын гурван чулуутай байсан уламжлалт сэтгүүл зүй өдгөө улс төр, нийгэм, бизнесийн эрх ашгийг илэрхийлэх үүрэг хүлээсэн олон нийтийн харилцааны ээдрээтэй талбар болж хувирчээ*

»

өөрийн онцлог бүхий хэвлэл мэдээллийн бодлогыг дэвшүүлж, сэтгүүл зүйн салбарын улс орны хөгжлийн асуудалд хандах “өнцөг”-ийг тодорхойлсон байдаг. Энэ талаар өмнө нь олон удаа хэлцэгдэж, санал бодол, шүүмж олонтаа хэвлэгдэж байсан төдийгүй либертари онолын үзэл баримтлал өнөөгийн Монголын хэвлэл мэдээллийн зах зээлийн суурь болж байгаа тул үр шим болоод сөрөг талыг бид сайн мэддэг, бас мэдэрдэг.

Харин “хөгжлийн сэтгүүл зүй” хэмээх нэрээр энэхүү өгүүлэлд цаашид томъёологдох мэдээлэл харилцааны үзэл баримтлал нь улс орны хөгжил, түүнд гүйцэтгэх хэвлэл мэдээллийн үүрэг оролцоог нарийвчлан тодорхойлсон онол юм.

**А**нх 1964 онд АНУ-ын их сургуулиуд хамтран хөдөө аж ахуйн судалгааны семинар зохион байгуулах үеэр “төр–хэвлэл мэдээлэл–олон нийт”-ийн гурвалсан харилцаанд уг салбарын хөгжлийн асуудлыг цогцоор шийдэх сэдэв хөндөгдөж “хөгжлийн төлөөх мэдээлэл харилцаа” (communications for development) гэсэн нэр томъёо гарсан<sup>4</sup>. Энэ нь улс орны хөгжлийн гарц болон тодорхой салбарын асуудалд төр, олон нийтийн анхаарлыг хандуулж, хэвлэл мэдээллийнхнийг татан оролцуулж нөлөөллийн кампанит ажил зохион байгуулснаар зохистой үр дүнд хүрнэ гэсэн үг юм. Чухам энэ үзэл санаа нь хожим Зүүн Өмнөд Ази, Төв болон Өмнөд Африк, Латин Америкийн улс орнуудад сэтгүүл зүйн томоохон чиглэл болон төлөвшсөн юм. Англи хэл дээрх эх сурвалжууд “Development journalism”, “journalism for sustainable

development”, “communications for development” гэх мэт хэд хэдэн янзаар томъёолон хэрэглэж буй ч угтаа нэг л үзэл баримтлал юм. Анхлан аливаа салбарыг өөд нь татахад хэвлэл мэдээллийг ашиглах санаа төдий байсан энэ ойлголтыг филиппинчүүд сэтгүүл зүйн томоохон онол болгож төлөвшүүлж чадсан юм. 1960-аад оны сүүлээс Филиппинд үндэс сууриа тавьсан хөгжлийн сэтгүүл зүй хожмоо гурав дахь ертөнцийн гэгддэг Ази, Африк, Латин Америкийн хөгжиж буй орнуудад түгэн дэлгэрсэн байна.

Хэдийгээр аливаа улс орны, салбарын хөгжлийн асуудал хэвлэл мэдээллийн хэрэгслийн байнгын сэдэв болж, нийтлэл, нэвтрүүлгийн бодлогод шингэсэн байдаг боловч Development journalism хэмээн томъёолсон энэхүү ойлголтын хүрээнд өөрийн гэсэн өвөрмөц зарчим, чиг шугамыг бий болгожээ. Тухайлбал, дараах онцлог шинжүүдийг агуулж, зарчимд нийцэж гэмээнэ дээрх томъёололд багтана. Үүнд<sup>5</sup>:

- Улс орны хөгжлийн гарцыг тодорхойлох салбар чиглэлийн талаар бүрэн дүүрэн, цогц, тогтмол бодитой мэдээллээр төр, олон нийтийн хэрэгцээг хангах, хэлэлцүүлэг өрнүүлэх,
- Өөрсдийн сонгосон чиглэл, салбарын мэдээллийг өөрийн ОНМХ-ийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлогын тэргүүн чиг шугам болгож төлөвшүүлэх,
- Хөгжлийн сэтгүүл зүйн сэдэв нь зөвхөн эдийн засаг, түүнтэй холбоотой зүйлс байх албагүй. Хүний хөгжил, хот, орон нутгийн хөгжил, ажилгүйдэл, ядуурал, тогвортой хөгжил, боловсрол, эрүүл мэнд г. м. өргөн хүрээг хамарч болно.

- Барууны орнуудын буюу глобал мэдээллийн эх сурвалжийн байр сууриас ангид байх,

- Зөвхөн өөрийн улс орны онцлог, бололцоо, нөөц, эрх ашгийг харгалзсан хөгжлийн гарцыг эрэлхийлэхэд тэмүүлэх,

- Хөгжлийн гарц хэмээн томъёолсон сэдэв, салбар, үзэгдэл, асуудлыг бүрэн дүүрэн судлах, хэлэцүүлэг өрнүүлэх, бүх түвшний эх сурвалж, олон нийтийн оролцоог хангах, төрийн бодлого, хөтөлбөрт нөлөөлөх,

- Улс төрийн хүчний ухуулга сурталчилгаанаас ангид байх.

Мөн хөгжлийн төлөө сэтгүүл зүй нь үндсэн хоёр үр дүнд хүрэхийг зорьдог: 1) гадаад улс орны шилдэг арга, туршлага, технологийг судлах, нэвтрүүлэх, “өөриймчлөх” (монголчлох), 2) тухайн сэдэв, чиглэлийн талаарх дотоодын иргэдийн санаа бодлыг төлөвшүүлэх, удирдан залах, чиглүүлэх, гурван талт нөлөөллийн “ажлыг” амжилттай хэрэгжүүлснээр төрийн бодлого болгож хувиргах.

**Х**эвлэл мэдээллийн хэрэгслийн болон сэтгүүлч хүний иргэний байр суурь, мэргэжлийн үүрэг нь ард түмний эрх ашгийн төлөө байдаг, байх ч ёстой. Ямар ч цаг үеийн, ямар ч улс орны төр, засгийн газар улс орноо хөгжүүлэх тодорхой бодлого баримталдаг нь жам. Чухам энэ хоёр сонирхлын давхцал нь хөгжлийн сэтгүүл зүйн орших үндэс болдог. Энэ нь тухайн цаг үеийн засгийн бодлогод “дулдуйдах” гэсэн үг огтоос биш бөгөөд харин ч хөгжлийн асуудалд бодитой, шүүмжлэлтэй хандаж, олон тийш, олон асуудалд тарамдсан төрийн нөөц бололцоо, эдийн засгийн чадамжийг

тооцоолон, цэгцэлж, нэг зүгт тууштай зорих сэдлийг бий болгоход гол зорилго оршино.

Хөгжлийн сэтгүүл зүйн бодит жишээ, уламжлал Монголд бий юу гэвэл бий. Шинэ үеийн сэтгүүл зүйн томоохон төлөөлөл болж байсан сэтгүүлч Л.Болормаа агсан 2008 онд эдийн засаг, уул уурхайн мэргэшсэн сэтгүүл үндэслэн, төр–салбар–олон нийтийг холбосон маш сайн гүүр босгож чадсан. Оюу Толгой, Таван Толгой, эрчим хүч, дэд бүтэц, төмөр замын бодлого гээд цаг үеийн олон сэдэв, үйл явдалд “Mongolian Mining Journal” сэтгүүл төрийн бодлогод нөлөөлж, олон нийтэд цэгцтэй мэдлэг, мэдээлэл олгож, уул уурхайн салбар нь дунд болон урт хугацаанд Монгол Улсын хөгжлийн түлхүүр болох ёстой гэдгийг ухамсарлахад өөрийн үүргээ биелүүлсэн. Мөн Л.Болормаа агсан “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-г байгуулан төвийн болон орон нутгийн сэтгүүлчдийг уул уурхай, эдийн засгийн сэдвээр мэргэшүүлэх чиглэлд ач холбогдол бүхий олон ажил зохион байгуулж явсан ба “Mongolian Mining Journal” сэтгүүл нь өнгөрсөн хугацаанд Монголын уул уурхайн салбарын тухай үнэ цэнтэй архив, мэргэжлийн сэтгүүлчдийн гарын авлага болж төлөвшсөнийг үгүйсгэх эрхэм гарахгүй байх.

Монголын ОНМХ-үүд технологийн дэвшил, хөгжлийн хандлагад хөл нийлж, хэлбэрийн хувьд амжилттай хөрвөж, дасан зохицож чадаж байгаа боловч агуулгын хувьд хэрхэн өөрчлөгдөхөө үл ухамсарлаж, өөр хоорондоо маркетингийн өрсөлдөөн өрнүүлэн, олон нийтийн хувьд зөвхөн мэдээллэх үйлчилгээ л үзүүлж буй нь

өнөө үед дутагдалтай бөгөөд хоцрогдолтой.

**М**асс медиа гэх ойлголт бидний явцууруулан томъёолсон ОНМХ-ээс хол даван гарсан өнөө үед зөвхөн мэдээлэх чиг үүрэг, цаг үе, үйл явдлын тухай “нүцгэн” баримтанд тулгуурласан сэтгүүл зүй оршин тогтнох нь эргэлзээтэй болсон. Улс төр, эдийн засгийн шалтгаануудын улмаас замхран, бүүдийж буй “мэргэжлийн сэтгүүл зүй”-г авч үлдэх хөрсийг бид бэлтгэх ёстой. Боломжит нэгэн хувилбар нь хөгжлийн сэтгүүл зүй. 5W&1H-ын түвшинд сэтгэж, гацаж үлдэх бус үзэл бодлын сэтгүүл зүйг төлөвшүүлэх шаардлага, цаг хугацаа, эрэлт хэрэгцээ цөм бүрдээд байна.

#### Ишлэл

1. *Наранбаатар Б.* 2014. Олон улсын асуудлыг эрэн сурвалжлах нь: туршлага ба хандлага // “Сэтгүүл зүй” МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №15/417. 237-р тал.
2. *Конев М.* 2014. Как изменилось понятие “журналистика” в современном цифровом пространстве // “Журналист”, № 10/2014, с. 124.
3. [http://mecs.ukzn.ac.za/libraries/311/lecture\\_notes\\_-\\_development\\_journalism.sflb.ashx](http://mecs.ukzn.ac.za/libraries/311/lecture_notes_-_development_journalism.sflb.ashx)
4. *Шумилина Т.* 2009. Включенная журналистика: гражданская позиция СМИ и социальная ответственность бизнеса // “Медиаскоп” научный журнал, № 03/2009. <http://mediascope.ru/node/402>
5. [devjournalism.wordpress.com/2011/04/21/history-of-development-journalism/](http://devjournalism.wordpress.com/2011/04/21/history-of-development-journalism/)

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Болд-Эрдэнэ Б.* 1999. Нийгэм, улс төр, хэвлэл мэдээлэл. УБ
2. *Зулькафиль М.* 2010. Монголын олон нийтийн мэдээлэл: нэг үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл. УБ.
3. *Манойло А. В.* 2003. Государственная информационная политика в особых условиях, монография. М.
4. *Зорин К. А.* Медиафутурология: «журналистика смысла» в условиях роботизации медиапроизводства и общества // Медиаскоп. 2016. Вып. 1.
5. *Нурғалиева Л.* 2006. Актуальные проблемы человечества и СМИ. М.
6. *Наранбаатар Б.* 2011. Освещение глобальных проблем современности в СМИ Монголии // Автореф. дисс. канд. филол. наук. М.

#### Резюме

Статья посвящается теме об информационных коммуникациях в целях развития страны, которые, по мнению автора, должны быть особо важными и ценными в нынешнем этапе развития журналистики в Монголии. В силу быстрого роста потребления гражданами информационно-коммуникационных средств в Интернет-пространстве, традиционные СМИ Монголии теряют былую значимость и охват аудитории, и в среде журналистики Монголии идёт активный поиск оптимального пути дальнейшего развития. Автор уделяет внимание тому, что журналистика в целях развития (в источниках на русском языке упоминаются аналогичные термины “включенная журналистика” или “коммуникации в целях развития”) может стать хорошей базой и перспективным направлением для СМИ и журналистов страны.